



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/540

Чойбалсан

Г Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт Г
шилжсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “л”, 39 дүгээр зүйлийн 39.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 53 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд эмнэлэг, эмийн сан, харилцаа холбоо, шуудан, дулаан хангамж, цахилгаан станц, худаг, усан хангамж, хэвлэл мэдээлэл, хүнсний дэлгүүр, хүнсний супермаркет, хүнсний зах, хүнс үйлдвэрлэл, шатахуун түгээгүүр, буяны ажлаас бусад үйл ажиллагааг хязгаарлан, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, гамшгаас хамгаалах орон нутгийн мэргэжлийн алба, мэргэжлийн ангиудаас бусад төрийн болон хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосугай.

2.Аймаг, сум, багаас гарах, орох бүх хөдөлгөөнийг дээрх хугацаанд хязгаарлан, байнгын пост, хөдөлгөөнт эргүүл томилон, хяналтыг өндөржүүлэн ажиллахыг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар /Г.Нармандах/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Цагдаагийн газар /Т.Ганзориг/, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд аймгийн төв Чойбалсан хотын бүх төрлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээг зогсоож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Т.Ганзориг/, Авто тээврийн төв /Ц.Мөнхтөр/, Хэрлэн сум /П.Мөнхтөр/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Иргэдийг хүнс бэлтгэх, эрүүл мэнд, ундны усны хэрэгцээг хангахаас бусад тохиолдолд нийтийн эзэмшлийн зам талбайд зорчихгүй байх асуудлаар олон нийтэд мэдээлж, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Олон нийттэй харилцах алба /Э.Батболд/, аймгийн Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, нийтийн эргүүл томилон, хяналт тавьж ажиллахыг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар /Г.Нармандах/, аймгийн Цагдаагийн газар /хурандаа Т.Ганзориг/, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Энэ захирамжийн 1 дүгээр заалтад зааснаас бусад төрийн байгууллагууд ажлын тусгай горимд шилжүүлж, зайнаас цахимаар ажиллах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, нэн шаардлагатай үүрэг гүйцэтгэх ажилчдаа ээлжээр ажиллуулж байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг нийт төрийн байгууллагын дарга, удирдлагуудад даалгасугай.

6.Захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлж, холбогдох байгууллагуудад шуурхай хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Ц.Баяржаргал/, Олон нийттэй харилцах алба /Э.Батболд/-нд тус тус даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Г.Нармандах/, Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Т.Ганзориг/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН